



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/40

Мандалговь

Бизнес эрхлэгчдийг дэмжих жилийн
ажлыг зохион байгуулах ажлын хэсэг
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "а", 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Гурван тулгуурт хөгжлийн бодлогын 3.1, 3.2, 3.3, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3 дахь заалтууд болон аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2021 оны "Бизнес эрхлэгчдийг дэмжих жил"-ийн ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсугай. Үүнд:

Дарга:	Л.Доржбат	(Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Г. Энхтайван	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
	Ш. Төрбат	(Мэргэжлийн хяналтын газрын дарга)
	Б.Мөнхжаргал	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
	Г.Хишигдаваа	(Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга)
	М.Туяацэцэг	(Татварын хэлтсийн дарга)
	Ю.Цолмон	(Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал)
	Э.Чагнаадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
	С.Бат-Оргил	(Сайнцагаан сумын Засаг дарга)
	А.Пүрэвсүрэн	(Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга)
	Б.Энхтуяа	(Статистикийн хэлтсийн дарга)
	М.Бат-Эрдэнэ	(Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Д. Ганмягмар	(ХААН банкны Дундговь салбарын захирал)
	Ч.Туяацэцэг	(ХАС банкны Дундговь салбарын захирал)
	Э. Хөхөөхүү	(Төрийн банкны Дундговь салбарын захирал)
	Д. Ганчимэг	(Монголын худалдаа аж үйлдвэрийн салбар танхимын дарга)
	Ж. Зоригтбаатар	(Ажил олгогч эздийн холбооны салбарын тэргүүн)
Нарийн бичгийн дарга:	Н.Эрдэнэ-Очир	(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Чиглүүлэгч:	Ц.Дамдин	(Номадс фүүд ХХК-ны захирал)

Хоёр. "Бизнес эрхлэгчдийг дэмжих жил"-ийн дэд ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

Гурав. Жилийн хүрээний ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд нийт сумд, байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, иргэдийн оролцоог ханган үр дүнтэй шуурхай зохион байгуулж ажлын явцыг сар бүр тайлагнаж ажиллахыг дэд ажлын хэсэг (М.Анхбаяр, Н.Эрдэнэ-Очир, Б.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

Дөрөв. "Бизнес эрхлэгчдийг дэмжих жил"-ийн ажлыг удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), ажлын явц, үр дүнд хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ, дотоод аудит

481210009

хийж аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Г.Самданцоодол)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ